



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 433

Улаанбаатар хот

Г Автомашины тоо, төрөл тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.


2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашин ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 9 дугаар сарын 26-ны өдрийн
13 дугаар тогтоослын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДОТООД АЛБАН АЖЛЫН
ХЭРЭГЦЭЭНД АШИГЛАГДАХ АВТОМАШИНЫ АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ**

№	Үндсэн ангилал	Төрөл	Тоо
1	Үйлчилгээний автомашин	Хөдөө ажлын автомашин /Жип/	2
2		Хот доторх ажлын суудлын автомашин	1
3		Хот доторх ажлын жижиг оврын автобус /Микро автобус/	2
Нийт автомашин			5